




МОНГОЛ УЛС  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



"ШИНЭ ХОТЖИЛТ" ХХК



# ГОВИЙН БУСИЙН ТАВАНТОЛГОЙ, ОЮУТОЛГОЙ, ЦАГААН СУВАРГЫН УУЛ УУРХАЙН ОРД ГАЗРЫГ ТУШИГЛЭСЭН БУС НУТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ ТАЙЛБАР

## УЛААНБААТАР ХОТ 2008 ОН



**“Говийн бүсийн хөгжлийн стратеги”,  
“Хот байгуулалтын төсөл”-ийн товч танилцуулга**

“Говийн бүсийн Таван толгой, Оюутолгой, Цагаансуваргын уул уурхайн орд газрыг түшиглэсэн бүс нутгийн хөгжлийн стратеги” төслийг Барилга, хот байгуулалтын яамны баталсан даалгаврын дагуу “Шинэ хотжилт” ХХК-д боловсруулав. Говийн бүсийн хөгжлийн стратеги төслийн хамрах хүрээнд Говьсүмбэр, Дорнговь, Дундговь, Өмнөговь аймгуудын нутаг дэвсгэр багтаж байгаагаас гадна Тавантолгой, Оюутолгой, Цагаансуваргын орд газрыг түшиглэсэн Дорнговийн Мандах, Хатанбулаг, Өмнөговийн Цогтцэций, Баян-Овоо, Манлай, Ханбогд зэрэг 6 сумуудын нутаг дэвсгэрийг хамарсан бичил бүсийн хот байгуулалтын төлөвлөгөө гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ.

### **Нэг. ГОВИЙН БҮСИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ**

Говийн бүсийн хөгжлийн стратеги төслийг эхнээс нь аль болох үндэслэлтэй, харилцан уялдаатай боловсруулах үүднээс холбогдох яамд, говийн бүсийн аймгуудын Засаг дарга нарын нэр дээр Барилга, хот байгуулалтын Сайдын албан тоот явуулж эхний ээлж /2007-2015 он/-д, төлөвлөлтийн хугацаа /2016-2021 он/-д улс, орон нутаг, гадаадын зээл тусlamжийн хөрөнгөөр дэд бүтэц, уул уурхай, үйлдвэр барилга, БОХ, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж байгаа түүнчлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээ, мөн уг төсөлд тусгах саналыг авсаны үндсэн дээр орон нутагт тодотгол судалгаа явуулж, төрийн бодлогын түвшинд баримталж байгаа Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал зэрэг тулгуур баримт бичгүүдтэй уялдуулан стратеги зорилтуудыг тодорхойлов.

Говийн бүсийн хөгжлийн түвшин, хөгжилд тэргүүлэх үүрэг бүхий эрдэс баялагийн нөөц, одоо байгаа болон цаашид бий болох магадлалтай дэд бүтцийн эх үүсвэр, үндсэн сүлжээнд түшиглэн говийн бүсийн хөгжлийг хурдасгахад төслийн зорилго оршино.

**Судалгаа, дүгнэлт, бүсчилсэн хөгжлийн үе шатны зорилтоос үүдэн Монгол Улсын өмнөд говь нутаг бие даасан бүсээр хөгжих угтвар нөхцөл бүрдсэн гэж үзэх үндэслэлтэй байна.**

Говийн бүсийн бие даасан хөгжилтэй уялдан Оюутолгой, Тавантолгойн орд газар, бүсийн чанартай дэд бүтцийн эх үүсвэр, үндсэн сүлжээг түшиглэсэн говийн бүсийн тулгуур төв хот – Оюутолгой, Цагаансуваргын орд газрыг түшиглэсэн орон нутгийн хот бий болохоос гадна үйлчилгээний зохистой хүрээний таталцалаар бүлэг суурингийн төвүүд үүсэх зэрэг нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалт, хүн амын нутагшилт, суурьшлын шинэ тогтолцоо бүрдэх хандлагатай байна.

**Говийн бүсийн хөгжлийн стратеги зорилтыг хөгжилд нөлөөлөх харьцангуй давуу болон сул хүчин зүйлүүдийг харьцуулан дараах таван үндсэн чиглэлээр тодорхойлов.**



Үүнд:


1. Оюутолгой, Тавантолгой, Цагаансуваргын уул уурхайн ордуудыг түшиглүүлэн дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай олборлох, баяжуулах үйлдвэрүүдийн цогцолборуудыг байгуулах, ашигт малтмалын бусад жижиг ордуудыг ашиглаж аж ахуйн эргэлтэнд оруулах, уламжлалт үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимжүүлэх замаар **говийн бүсийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх;**
2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын үндсэн чиг хандлага – Монгол Улс дэд бүтэц дээр суурилан хөгжинэ гэсэн дүгнэлтэд тулгуурлан **говийн бүсийн хөгжлийн угтвар нөхцөл – дэд бүтцийн үндсэн сүлжээг барьж байгуулах;**
3. Бүс нутгийн байгалийн баялагийн нөхцөлийн нөөцийг экологи, эдийн засгийн талаас нь сайтар үнэлж, **байгаль орчинд халгүй ашиглах арга зам, дэвшилтэд технологийг зөв сонгож нэвтрүүлэх;**
4. Говийн бүсэд хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх, гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг бууруулах иргэд өөрийн төрж өссөн нутаг орондоо тогтвортой оршин суух, **ая тухтай амьдралын баталгааг хангах, хүний хөгжлийн түвшинг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх;**
5. Говийн бүсийн нутаг дэвсгэрийн бүтэц, зохион байгуулалт, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж, хот суурины хөгжлийг шинэ шатанд гаргаж, **нутаг дэвсгэрийн түвшинд нийгэм эдийн засгийн бүх төрлийн үйлчилгээний голомт – бүсийн тулгуур төв хотыг үндэслэлтэй төлөвлөж барьж байгуулах;**

Хөгжлийн стратегийн зорилтуудыг 2015, 2020 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэлгэрэнгүй тусгаж гарах үр дүнг тодорхойлсон.

Говь нутгийн байгаль, ландшафтын онцлог, түүх соёл, археологи, палеонтологийн зэрэг нөхцөл нөөцөд түшиглэн амралт сувилал, аялал жуулчлал, БОХ-ын талаар стратеги болон хот байгуулалтын төлөвлөгөөнд тусд нь бүлэг болгон тусгасан.

Говийн бүсийн хөгжлийн стратеги төслийн судалгаа, нэгдсэн дүгнэлт, хэтийн хөгжлийн стратеги зорилтуудын талаар 2008 оны 5 дугаар сарын 1-нд Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод болсон “Өмнөд.govийн эрдэс баялаг хөгжлийн үндэс” сэдэвт улсын зөвлөгөөнд, 2008 оны 5 дугаар сарын 15-нд Монгол Улсын Өмнөд бүс нутгийн дэд бүтцийн стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх болсон Дэлхийн банк, Монгол Улсын Сангийн яам хамтран зохион байгуулсан дугуй ширээний уулзалтад тус тус илтгэл хэлэлцүүлж илтгэлүүдэд гарсан дэлгэрэнгүй мэдээлэл, хөгжлийн чиг хандлага, завсарын үр дүнг Говийн бүсийн хөгжлийн стратеги, Тавантолгой, Оюутолгой, Цагаансуваргын уул уурхайн орд газруудыг түшиглэсэн хоёр аймгийн 6 сумын нутаг дэвсгэрийг хамарсан бичил бүсийн хот байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.

Говийн бүсийн төслийн хамрах хүрээ, хөгжлийн чиг хандлага, хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцооны талаарх схемийг хавсаргав.





### Говийн бүсийн хүн ам, хөдөлмөрийн нөөц

Говийн бүсийн төсөлд хамрагдсан Говьсүмбэр, Дорнговь, Дундговь, Өмнөговь аймгуудад 163,9 мянган хүн ам амьдарч байгаа нь Монгол Улсын хүн амын 6,3 хувийг эзэлж байна.

### Хүн амын хэтийн төлөв

Дд	Аймгуудын нэр	2007 он		2015 он		2021 он	
		Мян. хүн	хувь	Мян. хүн	Хувь	Мян. хүн	хувь
1	Говьсүмбэр	12.6	7.6	18.0	7.5	25.0	6.0
2	Дорнговь	55.6	34.0	72.0	30.0	122.0	27.0
3	Дундговь	48.8	29.8	56.0	23.5	95.0	21.0
4	Өмнөговь	46.9	28.6	93.0	39.0	203.0	46.0
	Говийн бүсийн дүн	163.9	100.0	239.0	100.0	445.0	100.0



### Хотын хүн ам / мян. хүн /

Д/д	Хотуудын нэр	Одоо байгаа 2007 он	Эхний ээлж 2015 он	Төлөвлөлтийн хүн ам 2021 он
1	Чойр	9.7	14.0	18.0
2	Сайншанд	19.7	23.0	38.0
3	Мандалговь	13.7	16.0	26.0
4	Даланзадгад	15.2	18.0	29.0
5	Оюутолой	-----	30.0	85.0
6	Цагаансуварга	-----	8.0	15.0
Нийт		58.3	109.0	196.0

Говийн бүсийн нутаг дэвсгэр дээр байгаа стратегийн ач холбогдолтой ашигт малтмалуудын ордуудыг түшиглэж шинээр хоёр хот үүсэж, төв суурингийн тоо нэмэгдэж, төвөөс хөдөөрүү шилжих хөдөлгөөн иксэж, хотжих үйл явц эрчимжинэ.

### Техник эдийн засгийн үзүүлэлт

Дд	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Төлөвлөлтийн хугацаа		
			2007 он	2015 он	2021 он
1	Нутаг дэвсгэр	Мян.га	35508.4	35508.4	35508.4
	Хөдөө аж ахуйн газар - Тариалангийн талбай - Хадлан - Бэлчээр Хот тосгоны эдэлбэр газар Зам шугам сүлжээний газар Ойн сан бүхий газар Усан сан бүхий газар Улсын тусгай хэрэгцээний газар	Мян. га Мян. га Мян. га Мян. га Мян. га Мян. га Мян. га Мян. га Мян. га Мян. га	29158.6 0.4 7.9 28359.5 48.7 90.6 961.6 52.9 5195.8	27493.4 1.3 9.2 26692.5 54.7 115.3 986.8 52.9 6815.8	25827.4 5.8 11.5 25019.7 60.8 136.8 1011.9 52.9 8435.8




2	Хүн амын тоо				
	Говийн бүсийн нийт хүн ам Нийт өрх Говийн бүсийн хүн амын улсад эзлэх хувь Хотуудын хүн ам Хотын өрх Хотуудын хүн амын улсад эзлэх хувь	Мян. хүн тоо хувь Мян. хүн тоо хувь	163.9 40.0 6.3 58.3 14.0 2.2	239.0 58.0 9.1 109.0 26.6 4.1	445.0 109.0 16.8 211.0 51.5 8.0
3	Нутагшилт, төв суурин				
	Нийт төв суурин газрын тоо Үүнээс: тулгуур төв- хот аймгийн төв хот орон нутгийн хот бүлэг суурингийн төв хөдөөгийн суурин хоторхуу суурин	Тоо тоо тоо тоо тоо тоо тоо	49 - 4 - - 43 2	61 1 4 2 8 35 11	61 1 4 2 8 35 11
4	Дэд бүтцийн сүлжээ				
	Зам тээврийн сүлжээ Үүнээс: Авто замын нийт урт Говийн бүсийн чанартай авто зам: босоо чиглэлийн хэвтээ чиглэлийн бүлэг суурингийн чанартай Төмөр замын нийт урт: Үүнээс босоо чиглэлийн хэвтээ чиглэлийн	Км км км км км км км км км км км км км км	----- ----- ----- ----- ----- 289.0 ----- ----- ----- ----- ----- ----- ----- ----- -----	330.0 330.0 ----- 330.0 ----- 1139.0 850.0 340.0 510.0	3611.0 3281.0 526.0 1142.0 1613.0 1783.0 644.0 268.0 376.0
	Эрчим хүчний хангамж Цах. станц Д.Ц.С. Дэд станц Дизель Сэргээгдэх эрчим хүч Цахилгаан дамжуулах шугамын урт Үүнээс: 15квт 220 квт	МВТ МВТ кВт тоо тоо км км км км км	--- 3 1 2 9 2 --- --- --- ---	3600 300 220 /110 --- --- 680.0 --- --- 680. 0	--- --- --- 220 / 110 --- 1648.0 968.0 668.0 300.0
5	Аялал жуулчлал, амралт сувилал				
	Жуулчдын баазын тоо Амралт газар Сувилалын газар Хүүхдийн зуслан	Тоо тоо тоо тоо	42 5 3 2	4 --- 1 1	4 1 2 1



## Говийн бүсийн хөгжлийн стратеги төслийг

### хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

- Говийн бүсийн хөгжлийн стратеги зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд уул уурхайн орд газруудын олборлох түвшингөөс боловсруулах шатанд шилжих эрх зүйн орчинг бүрдүүлж, уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолборуудыг барьж байгуулах угтвар нөхцөл болох дэд бүтцийн эх үүсвэр, үндсэн сүлжээг бий болгох.
- Говь бие даасан бүсээр хөгжих стратегийг баталгаажуулж, Говийн бүсийн удирдлага, зохион байгуулалтыг арга хэмжээг цаг алдалгүй авч Говийн бүсийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.
- Говийн бүсийн хөгжлийн тулгуур төв хотын байршил, усны эх үүсвэрийн судалгааг ойрын хугацаанд хийж, хотын ерөнхий төлөвлөгөөг олон улсын тендер шалгаруулж гүйцэтгэх.
- Цагаансуваргын уул уурхайн орд газрыг түшиглэн байгуулагдах орон нутгийн хот болон Замын-Үүд хот - Чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.
- Говийн аймгуудаас аймаг хөгжүүлэх төсөл нь хийгдээгүй ашигт малтмалын томоохон ордуудтай Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хөгжлийн төслийг ойрын хугацаанд боловсруулах.
- Говийн бүсийн Шивээхүрэн, Нарийнсухайт, Хангий-Мандалын хилийн боомтуудыг хэрхэн хөгжүүлэх, нийгмийн асуудал, барилгажилт, тохижилтын талаар багц асуудлыг боловсруулж шийдвэрлэх.





# **БУСИЙН ХӨГЖЛИЙН ХЭВТЭЭ, БОСОО ТЭНХЛЭГ ТУЛГУУР ТӨВ ХОТУУД**

**ГОВИЙН БУСИЙН ТАВАНТОЛГОЙ, ОЮУТЛОГОЙ, ЦАГААНСУВАРГЫН  
УЛ УРХАЙН ОРД ГАЗРЫГ ТУШИГЛЭСЭН  
БУС НУТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨСЕЛ**

УЛСЫН НИЙСЛЭЛ  
БУСИЙН ТУЛГУУР ТӨВ  
АЙМГИЙН ТӨВ

10

A map of the Chanty-Mansi Autonomous Okrug, Russia. The map shows the outline of the autonomous okrug and several rivers. A red dashed line highlights a specific river, which is labeled 'ГАШУН-ХУШАКТ' (Gashun-Hushakt) in black text. The river flows generally from west to east, with its source area indicated by a red circle.

График зависимости УВД от времени. Ось времени (DATA) имеет деления в 10, 20, 30, 40, 50, 60, 70, 80, 90, 100. Ось УВД имеет деления в 0, 10, 20, 30, 40, 50, 60, 70, 80, 90, 100. Красная линия с погрешностью показывает рост УВД с временным задержкой. Чёрная линия с погрешностью показывает моментальный рост УВД.

ЗАМ/ГАНЫ МЯНГАЛЫГЭ

УЛСЫН ХИЛ  
БУСИЙН ХИЛ  
АЙМГИЙН ХИЛ  
ХЭВТЭЭ ТЭНХЛЭЭ  
БОСООТЭНХЛЭЭ

A set of color calibration bars used for printing and scanning. It includes vertical bands of red, orange, yellow, green, blue, and black.


МИНГАНЫ ЗАМЫН ҮЙЛЧЛЭЛИЙН ХҮРЭЭ  
ТӨМӨР ЗАМ



ШИНЕХОТСЫН


**БУС НҮТГИЙН ТӨГТПОЛЦОО, УЛС, БУСИЙН ДЭД БҮТЦИЙН  
СУЛЖЭЭНД ХОЛБОГДСОН БАЙДАЛ**


"ТОВИЙН БУСИЙН ТАВАНТОЛГОЙ, ОНОУТОЛГОЙ, ЦАГААН  
СУВАРГЫН УЛС УУРХАЙН ОРД ГАЗРЫГ ТУШИЛГЭСЭН БУС  
НҮТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ" ТӨСӨЛ





## ГОВИЙН БУСИЙН ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ТЭНХЛЭГ, ТУЛГУУР ТӨВ








THE VOYAGE

ГОВИЙН БУСИЙН ХӨГЖЛИЙН БҮЛЭГ СУРИНГИЙН ТОГТОЛЦОО


**ГӨСВИЙН БҮСНИЙ ТАВАНТОЛ ОЙ, ЭКОЛОГОЙ, ЦАГААНСУВАРТЫН  
УП УРХАЙН ОРД ГАЗРЫГ ТУШИЛГЭЭН  
БҮС НҮҮГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ТӨССӨЛ**






ГОВИЙН ГҮССИЙН ЗАМ ТЭЭВРИЙН СҮЛЖЭЭ

**ГОВИЙН БУСМЫН ТАВАН ТОЛОЙ, ОНОУТОЛОЙ, ЦАГААНСУВАРТЫН  
УЛУУРХАЙН ОРДГАЗРЫГЧИЛЭСН  
БУС НҮТГИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТАСААЛ**







**Хоёр. ГОВИЙН БҮСИЙН ТАВАНТОЛГОЙ, ОЮУТОЛГОЙ,  
ЦАГААНСУВАРГЫН УУЛ УУРХАЙН ОРД ГАЗРЫГ ТУШИГЛЭСЭН БҮС  
НУТГИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОВЧ  
ТАНИЛЦУУЛГА**

**Төслийн хамрах хүрээ.** Өмнөговь аймгийн Баян-Овоо, Мандах Ханбогд, Цогтцэций, Дорноговь аймгийн Манлай,Хатанбулаг сумуудын нутаг дэвсгэрийг хамарч, б төв суурин газруудын хэтийн хөгжлийн төлөвийг тодорхойлно.. Өмнөговь,Дорноговь 2 аймгийн 6 сумын нутаг дэвсгэр дээр уул уурхай түшиглэсэн хот суурин шинээр үүссэж байгаа тул цаашид бичил бүсийн хэмжээнд төлөвлөлтийг боловсруулав

**Төслийн бүтэц**

1. Говийн бүсийн хөгжлийн стратеги,чиг хандлага,бичил бүс нутгийн хөгжлийн төлөв.
2. Байгалийн нөхцөл нөөц.
3. Говийн бичил бүсийн газар ашиглалт,төлөвлөлт.
4. Бичил бүс нутгийн хот байгуулалтын үнэлгээ.
5. Бичил бүсийн эдийн засаг,хүн ам,нийгийн дэд бүтэц.
6. Бичил бүсийн нутаг дэвсгэрийн инженерийн дэд бүтэц.
7. Говийн бичил бүсийн хот байгуулалтын төлөвлөгөө.
8. Сум суурин газруудын төлөвлөлт.
9. Байгаль орчны хамгаалал,аялал жуулчлал,амралт сувилалын хэтийн төлөв.
10. Төслийн үндсэн шийдэл,хэрэгжүүлэх арга хэмжээ гэсэн үндсэн арван бүлэгтэй,дотроо чиглэл тус бүрээр дэд бүлгүүдтэй.

**Зураглалын хэсэг.**

1. Бүс нутгийн тогтолцоо, улс, бүсийн дэд бүтцийн сүлжээнд холбогдсон байдал M1:500 000,
2. Бичил бүсийн нутаг дэвсгэрийн одоогий байдал,орд газруудын байршил M1:500 000,
3. Бичил бүсийн нутаг дэвсгэрийн хот байгуулалтын үнэлгээ M1:500 000,
4. Бичил бүсийн эрчимтэй таталцал, нутаг дэвсгэрийн хуваарилалт,хот суурины үүргийн ялгаа M1:500 000,
5. Байгаль хамгаалал,аялал жуулчлал,амралт сувилал,
6. Бичил бүсийн хэтийн төлөв M1:500 000 гэсэн нэртэй 6 төрлийн зураглалын материалаас бүрдэнэ.



### Үнэлгээ.

Бичил бүсийн нутаг дэвсгэрийг байгалийн хүчин зүйл болох газрын гадарга, өндөржилтийн түвшин, уур амьсгал, усан хангамж, инженер геологийн нөхцөл, газар чичирхийлэл гэх мэт зүйлсийг харгалзан үнэлсэн болно.

Бичил бүс нутгийн хөгжлийн төсөлд хамрагдсан 6 сумын төвүүд нь байгаль-экологи, нийгэм-эдийн засаг, хот байгуулалтын нэгдсэн үнэлгээгээр

- Баян-Овоо, Манлай, Ханбогд, Мандах, тохиромжтой,
- Цогтцэций, Хатанбулаг хязгаарлагдмал тохиромжтой үнэлгээтэй байна.

### Хүн ам

Бичил бүсийн нутаг дэвсгэрт одоогоор 14 900 хүн амьдарч, 8 төв суурин газар үйл ажиллагаа явуулж байна.

Оюутолгой, Тавантолгой, Цагаансуваргын уул уурхайн орд газруудыг хамарсан **бичил бүсийн хүн амын суурьшлын тогтолцоо бүрдэх хэтийн хөгжлийн төлвийг** бүс нутгийн хэмжээний дэд бүтцийн үндсэн сүлжээ, эх үүсвэрүүд болон бүх төрлийн нийгмийн үйлчилгээний зохистой хүрээтэй уялдуулан төлөвлөсөн.

Говь бие даасан бүсээр хөгжих стратеги зорилтыг хангах үүднээс бичил бүсийн хот төв суурин газруудын үйлдвэрлэл үйлчилгээний цогцолборуудын ажиллагсад, хот бүрэлдүүлэгч хүчин зүйлд тулгуурлан хүн амыг тооцож, хот байгуулалтын нормын дагуу нийгэм, соёлын үйлчилгээг төлөвлөсөн

### Бичил бүсийн нийт хүн ам 2021 он

ДД	Бүлэг суурингийн нэр	ДД	Хамрагдах төв суурингийн нэр	Хүн амын тоо мянган хүн
1	Оюутолгой –Шинэ хот	1	Оюутолгой хот	85.0
		2	Ханбогд	10.0
		3	Баян-Овоо	3.5
		4	Оюутогой тосгон	25.0
		5	Гашуунсухайт	1.5
			Бүгд	125.0
2	Цогтцэций	1	Цогтцэций	4.5
		2	Манлай	4.8
		3	Тавантолгой тосгон	1.0
			Бүгд	10.5
3	Цагаансуварга	1	Цагаансуварга	15.0
		2	Мандах	3.2
		3	Хатанбулаг	6.0
		4	Хангимандал	1.2
			Бүгд	25.4
		12	Нийт	160.7



## Инженерийн дэд бүтэц.

Говь бие даасан бүсээр хөгжиж хөгжлийн тэнхлэгүүд үүссэх тул авто ба төмөр замын тэнхлэг эрчим хүчний хангамжийн чиглэлүүдийг үндэслэж бичил бүсийн дэд бүтцийг дараах байдлаар төлөвлөв.

**Зам тээврийн сүлжээ.** Бичил бүсийн нутаг дэвсгэр дээр авто замын сүлжээний босоо 2, хэвтээ 1 тэнхлэгтэй байна.

- Босоо чиглэлийн Мандалговь –Цогт-Овоо-Тавантолгойн –Оюутолгой-Гашуунсухайт хилийн боомт 340 км
- Чойр-Баянжаргалан-Өндөршил-Мандах-Цагаансуварга-Хатанбулаг-Хангимандал хилийн боомт 478 км,
- Хэвтээ чиглэл Замын-Үүд-Улаанбадрах-Хөвсгөл-Хатанбулаг-Ханбогд-шинэ хот Оюутолгой-Даланзадгад 680км

Төмөр замын сүлжээ нь босоо ба хэвтээ 2 чиглэлтэй

- Хэвтээ чиглэлийн Зүүнбаян-Цагаансуварга-Оюутолгой-Тавантолгой 510 км,
- босоо чиглэлийн Тавантолгой-Оюутолгой-Гашуунсухайт хилийн боомт 254 км

**Эрчим хүчний хангамж** Засгийн газрын хөгжлийн хөтөлбөр, эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөрт 2007-2012 онд хэрэгжүүлэхээр тусгагдсаны дагуу

- Улаанбаатар-Мандалговь-Тавантолгой-Оюутолгойн-ордыг холбосон 220кВт-ын ЦДШ,
- Тавантолгой нүүрсний уурхайг түшиглэсэн 300МВт-ын ДЦС барих
- Чойрын дэд станцаас Цагаансуваргын уурхайг холбосон 220 кВт-ын ЦДШ

## Холбоо мэдээлэл

- сумын төв суурин газрууд нь АТС –тай ,радио телевизийн үүлчилгээтэй,
- Ханбогд, Цогтцэций Оюутолгой ,Тавантолгой хөтөлгөөнт холбоотой ,
- 2008 онд Баян –Овоо, Мандах, Хатанбулаг, Манлай сумууд холбогдоно.

## Усан хангамж

- Орхон- говь ,Хэрлэн- говь төслийн ус дамжуулах шугам,
- Гүний хоолойн газрын доорхи усны ордыг ашиглана.
- Төв суурин газрууд нь одоо байгаа ба шинээр гүний худаг гаргаж усан хангамжийн нэгдсэн системд холбогдоно.

## Нутаг дэвсгэрийн бүтэц зохион байгуулалт.

Говийн бүсийн хөгжлийн стратеги төслийн зорилтын хүрээнд боловсруулсан нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын бүтэцийг түшиглэж бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу эдийн засгий хувьд үр ашигтай



нийгмийн чиг баримжаатай болгох хөдөөгийн хөгжлийн бодлогыг дэмжиж, аймаг орон нутгийн санал, хөгжлийн бодлого, засаг захиргааны хил зэргийг харгалзсан тул 2 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан бичил бүсийн тогтолцоо үүссэж байна.

Тавантолгой, Оюутолгой, Цагаансуваргын уул уурхайн орд газруудыг түшиглэсэн 6 сумын нутаг дэвсгэрийг хамарсан бичил бүсийг **нутаг дэвсгэр зохион байгуулалт төлөвлөлтийн** хувьд дэд бүтцийн сүлжээнд хамрагдах байдал нийгмийн үйлчилгээний зохистой хүрээ таталцаар нь :

- Өмнөговь аймагт-2,
- Дорноговь аймагт-1,
- нийт-3 бүлэг суурингийн тогтолцоотой байхаар төлөвлөв.

Өмнөговь аймгийн 4 сумын нутаг дэвсгэрийн байршлын дунд нэг хот, Дорноговь аймгийн 2 сумын дунд нэг хот шинээр 2 хот үүссэж байна.

### Шинээр үүссэн хотууд бусад төв сууринтай холбогдох байршлын зайд

ДД	Шинэ хотуудын нэр	Хамрагдах төв суурингийн нэр	Алслагдсан зайд км	Тайлбар
1	Оюутолгой	Ханбогд	75.0	Оюутолгой хот Цагаансуварг аас 154.0 км зайтай
		Баян-Овоо	70.0	
		Оюутолгой тосгон	65.0	
		Цогтцэций	100.0	
		Тавантолгой тосгон	80.0	
		Манлай	100.0	
2	Цагаансуварга	Мандах	75.0	
		Хатанбулаг	80.0	

### Хөгжлийн тэнхлэг ба тулгуур төв хот

Аливаа нутаг дэвсгэрийн хөгжил дэд бүтэц дээр суурилан хөгжих болсон өнөө үед дэд бүтцийн сүлжээний үндсэн суурь тавигдаж баригдаж ашиглаж эхлэсний дараа хөгжлийн тэнхлэг үүсэн хөгжих бололцоотой болно.

Бичил бүсийн нутаг дэвсгэр дээр баригдах авто ба төмөр зам, эрчим хүчний шугам нэг коридорт давхцаж байгаа тул **хөгжлийн үндсэн тэнхлэг** үүсгэнэ, дангаараа баригдах авто ба төмөр зам, эрчим хүчний шугам нь **хөгжлийн туслах тэнхлэг** бий болгож, хөгжлийн үндсэн тэнхлэг дээр ирээдүйн.govийн бүсийн тулгуур төв-хот, туслах тэнхлэг дээр орон нутгийн хотууд бий болно.



### Бичил бүсийн төв суурингийн хүн ам 2021 он

ДД	Бүлэг суурингийн нэр	ДД	Хамрагдах төв суурингийн нэр	Хүн амын тоо мянган хүн
1	Оюутолгой –Шинэ хот	1	Оюутолгой хот	85.0
		2	Ханбогд	6.0
		3	Баян-Овоо	1.5
		4	Оюутолгой тосгон	25.0
		5	Гашуунсухайт	1.5
			Бүгд	119.0
2	Цогтцэций	1	Цогтцэций	3.0
		2	Манлай	1.5
		3	Тавантолгой	1.0
			Бүгд	5.5
3	Цагаансуварга	1	Цагаансуварга	15.0
		2	Мандах	1.3
		3	Хатанбулаг	2.5
		4	Хангимандал	1.2
			Бүгд	20.0
		12	Нийт	144.5

Говь бие даасан бүсээр хөгжиж шинээр үүссэн Оюутолгой хот нь бусад сум суурин, тосгоны таталцлын төв болж тэргүүлэн хөгжих ба бүсийн тулгуур төв- хот болно. Бичил бүсийн төв суурингуудыг хот суурины 5 ангилалд хувааж, цаашид тэргүүлэн хөгжих үүрэг зориулалтаар нь төв суурин тус бүрийг дараах байдлаар ангилаа.

#### Хот төв суурин газруудын ангилал ,үүрэг зориулалт

Хот суурины ангилал	Тоо ширхэг	Төв суурингийн нэр	Төв суурингийн үүрэг зориулалт
Бүсийн тулгуур төв хот	1	Шинэ хот - Оюутолгой	Засаг захиргаа олон нийт үйлчилгээний төв
Орон нутгийн хот	1	Цагаансуварга	Засаг захиргаа уул уурхай
Бүлэг суурингийн төв	1	Цогтцэций	Хөдөө аж ахуйн фермерийн аж ахуйн чиглэл
Хоторхуу суурин	4	Тавантолгой	Уул уурхай хүнд үйлдвэрийн төв
		Оюутолгой	Уул уурхай ,тээвэр
		Хангимандал	Хилийн боомт
		Гашуунсухайт	Хилийн боомт
Хөдөөгийн суурин	5	Манлай	ХАА-н хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн чиглэл
		Ханбогд	ХАА-н аялал жуулчлал, амралтын төв
		Баян-Овоо	ХАА-н, хил орчмын худалдаа үйлчилгээний төв
		Мандах	ХАА-н, аялал жуулчлал
		Хатанбулаг	Засаг захиргаа, ХАА-н үйлдвэрлэл
Нийт	12		



**Сум суурин газруудын төлөвлөлт.** Төсөлд хамрагдсан Баян-Овоо, Мандах, Манлай, Ханбогд, Хатанбулаг, Цогцэций сумуудыг хэтийн хөгжлийн байдалтай уялдуулж

- орчны тойм
- сумын төвийн авто зам тээврийн сүлжээ,
- нутаг дэвсгэрийн үүрэг зориулалтын бүсчлэл,
- инженерийн эх үүсвэрийн байршлыг тогтоож тус бүрд нь зураглал хийсэн.

### **Байгаль орчны хамгаалал, аялал жуулчлал, амралт сувилалын хэтийн төлөв**

Говийн бичил бүсийн нутаг дэвсгэрийн нөхцөл нөөцөд түшиглэн аялал жуулчлалыг зөв зохистой бодлого хөтөлбөрийн дагуу хөгжүүлснээр байгаль орчноо хамгаалах, эдийн засгийн чадавхи амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чухал түлхэц болно.

Говийн бичил бүс нутгийн нутаг дэвсгэрт байгаа Говийн бага дархан газар Байгалийн нөөц газар, байгалийн сонин тогтоцтой үзэсгэлэнт газрууд, архитектур, түүх соёлын дурсгалуудыг холбосон аялал жуулчлал, амралт сувилалын бүсүүд, үндсэн маршрутыг төлөвлөлөө.

Байгалийн үзэсгэлэнд түшиглэсэн АЖ-ын бүстүүх соёлын дурсгалд түшиглэсэн АЖ-ын бүсүүд төлөвлөж шинээр

- жуулчдын бааз-2
- амралт рашаан сувилал-2,
- хүүхдийн зуслан-2 байхаар тусгав. Бүсийн инженерийн дэд бүтэцтэй уялдуулж аялал жуулчлалын маршрутыг олон улсын болон улсын, орон нутгийн чанартай гэж ангиллаа.

### **Говийн бүсийн хөгжлийн бичил бүсийн техник эдийн засгийн үзүүлэлт**

Дд	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	2007 он	2015 он	2021 он
1	Нутаг дэвсгэр	Мян.га	7661.9	7661.9	7661.9
	Хөдөө аж ахуйн газар Тариалангийн талбай Хадлан Бэлчээр Хот тосгоны эдэлбэр газар Зам шугам сүлжээний газар Ойн сан бүхий газар Усан сан бүхий газар Улсын тусгай хэрэгцээний газар	Мян.га мян. га мян.га мян.га мян.га мян.га мян. га мян. га мян. га мян. га	5911.3 0.03 - 5621.2 3.5 7.4 262.6 12.1 1464.7	5898.7 0.470 - 5597.1 5.9 12.7 267.6 12.1 1464.7	5878.4 1.2 - 5581.0 15.9 17.9 272.6 12.1 1464.7





2		Хүн амын тоо				
		Бичил бүсийн нийт хүн ам Нийт өрх Бичил бүсийн хүн амын улсад эзлэх хувь Төв суурингийн хүн ам төв суурингийн өрх төв суурингийн хүн амын улсад эзлэх хувь	Мян. хүн мян. өрх хувь Мян. хүн мян. өрх хувь	14.9 3.6 0.6 4.4 1.1 0.2	68.0 16.6 2.6 56.5 13.8 2.1	160.7 39.2 6.1 144.5 35.2 5.5
3	Нутагшилт, төв суурин					
		Нийт төв суурин газрын тоо Үүнээс: тулгуур төв- хот орон нутгийн хот бүлэг суурингийн төв хөдөөгийн суурин хоторхуу суурин	Тоо тоо тоо тоо тоо тоо	8 ----- ----- 1 6 2	12 1 1 1 5 4	12 1 1 1 5 4
4	Дэд бүтцийн сүлжээ					
		Зам тээврийн сүлжээ <b>Үүнээс: Авто замын нийт урт</b> Бичил бүсийн чанартай авто зам: босоо чиглэлийн хэвтээ чиглэлийн <b>Төмөр замын нийт урт</b> босоо чиглэлийн хэвтээ чиглэлийн	Км км км км км км	----- ----- ----- ----- 764.0 254.0	254.0 ----- 254.0 ----- ----- 764.0	1165.0 ----- 485.0 680.0 ----- -----
		Эрчим хүчний хангамж Д.Ц.С. Дэд станц Дизель Сэргээгдэх эрчим хүч Цахилгаан дамжуулах шугамын урт Үүнээс: 15квт 220 квт	МВТ кВт тоо тоо км км	--- 2 6 3 --- ---	300 220 /110 --- --- 680.0 680. 0	--- 220/ 110 --- --- 715.0 415.0 300.0
5	Аялал жуулчлал, амралт сувилал					
		Жуулчдын баазын тоо Амралт сувилалын газар Хүүхдийн зуслан	Тоо тоо тоо	--- 2 ---	2 1 1	--- 1 1



**БИЧИЛ БУСИЙН НУТГАГ ДЭВСГЭРИЙН ОДООГИЙН  
БАЙДАЛ, ОРД ГАЗРУУДЫН БАЙРШИЛ**

“Говийн бусийн тавантолгоi, очиголгоi, цагаан  
сувагчын уулзурхайн орд азьгүүшийн төслийн  
хот байгуулалтын төвлөгөө








**БИЧИЛ БУСИЙН ЭРЧИМТЭЙ ТАТАЛЦАЛ, НУТГАГ ДЭВСГЭРИЙН  
ХУВИАРЛАЛТ, ХОТ СУУРИНЫ УҮРГИЙН ЯГЛАА**

"Говийн бусийн тавантолой, оюултой, цагаан  
сувартын уул урхайн орц Азьыг түшигэсэн бус  
хот байгуулалтын төвийн зүйлс"

ЗУРАГ 7.6






**БҮС НУТГИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ  
БИЧИЛ БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТЭНХЛЭГ, ТУЛГУУР ТӨВ ХОТ**

ТОВЫНД БҮСИЙН ТАВАНЦОСОЙ, ОЮУЦОСОЙ,  
ЦАДАН СҮРҮҮРТН ҮД ТУРХАН ОРДААРЫГ  
ХОТ БАЙН УЗИЛТИЙН ГОЛНГОЛОТЫН ЕС

ЗУРАГ 7.2





**БИЧИЛ БУС НҮТПИЙН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ  
ДЭД БУТЦИЙН СУЛЖЭЭ**

ТОВАЙН БУСЫН ТАВАН ОЙ ОЙ СКОУГОЛОДА  
ЦГААН СУВАРТЫН УУЛ УРКАН СОРЛЫАРЫГ  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨН  
ТҮШМПСЭН БУС НҮТПИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТОСГИЛ

ЗУРАГ 6.1-4

